



ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 09 сарын 22 өдөр

Дугаар А/181

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1, Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйл, Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.1, Эрүүл мэндийн сайдын 2022 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/330 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн төслийн үзэл баримтлал, хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, хуулийн төсөл боловсруулах “Ажлын хэсэг”-ийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажлын хэсгийн ажиллах удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Ажлын хэсгийг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (П.Цэцгээ), ажлын хэсгийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудит, үнэлгээний асуудал хариуцсан мэргэжилтэн (Л.Мягмардорж) нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Д.НАРАНТУЯА

Эм, эмнэлгийн харэгслийн хяналт,
зохицуулалтын газрын даргын 2022 оны 01
дугаар сарын 21-ны өдрийн 01/01 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга:	Эмийн аюулгүй байдлын тандалт, судалгааны газрын дарга
Нарийн бичгийн дарга:	Эмийн аюулгүй байдлын тандалт, судалгааны газрын ахлах мэргэжилтэн Дотоод аудит, үнэлгээний асуудал хариуцсан мэргэжилтэн
Гишүүд:	Захиргаа, удирдлагын газрын дарга Лиценз, зөвшөөрлийн зохицуулалтын газрын дарга Чанар хяналтын газрын дарга Эм хангамжийн газрын дарга Эмнэлгийн тоног төхөөрөмжийн газрын дарга Эмийн бүртгэлийн хэлтсийн дарга Эм үйлдвэрлэлийн хэлтсийн дарга Эм шинжлэх лабораторийн дарга Лиценз, зөвшөөрлийн зохицуулалтын газрын ахлах мэргэжилтэн Микробиологийн лабораторийн техник хариуцсан ахлах шинжээч Эмийн бүртгэлийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

Эм үйлдвэрлэлийн асуудал хариуцсан
ахлах мэргэжилтэн

Эм, биобэлдмэлийн хяналтын улсын
байцаагч

Эмийн үнийн зохицуулалт, өртөг үр дүн,
эдийн засгийн судалгааны асуудал
хариуцсан мэргэжилтэн

Вакцин, биобэлдмэлийн чанар, аюулгүй
байдал, зохицуулалтын асуудал хариуцсан
мэргэжилтэн

Хуулийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой
байдлын үеийн эм, эмнэлгийн хэрэгслийн
хангамж, зохицуулалтын асуудал
хариуцсан мэргэжилтэн

Нийслэлийн эрүүл мэндийн байгууллагын
эмнэлгийн тоног төхөөрөмжийн асуудал
хариуцсан мэргэжилтэн

Эрүүл мэндийн байгууллагын дэд бүтэц,
эмнэлгийн тоног төхөөрөмжийн
судалгааны асуудал хариуцсан
мэргэжилтэн

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт,
зохицуулалтын газрын даргын 2022 оны 09
дугаар сарын 23-ны өдрийн 01/21 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УДИРДАМЖ

Нэг. Үндэслэл

Монгол Улсад Эмийн тухай хууль 1998 онд батлагдан, 2006, 2010 онуудад шинэчлэн найруулгаар эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль батлагдаж, 2011, 2012, 2015, 2018, 2020 онуудад нэмэлт өөрчлөлт орсон.

Монгол Улсын Засгийн газраас 2019 оны 05 дугаар сарын 03-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Эм, эмнэлгийн хэрэглэгдэхүүний тухай хуулийн төслийг Засгийн газрын 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 28 дугаар хуралдааны тэмдэглэлд хуулийн төслийг татан авсан.

Иймд Эрүүл мэндийн сайдын 2022 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” А/330 дугаар тушаалаар техникийн ажлын хэсэг байгуулагдсан. Тус ажлын хэсэг эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг богино хугацаанд эрх бүхий байгууллагад өргөн мэдүүлэх шаардлагатай байгаа тул ажлын хэсгийг шаардлагатай мэдээ, мэдээллээр ханган, холбогдох саналыг хүргүүлж, төсөл боловсруулах үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай байна.

Хоёр. Зорилго

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандах, эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх, хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төсөл боловсруулахад шаардлагатай мэдээ мэдээллээр хангаж, холбогдох саналыг цаг тухайд нь Эрүүл мэндийн яаманд хүргүүлэх.

Гурав. Зорилт

Дараах зорилтын хүрээнд Эрүүл мэндийн сайдын 2022 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/330 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээ, мэдээллээр хангаж, холбогдох саналыг хүргүүлж ажиллана.

Дөрөв. Хэрэгжүүлэгч байгууллага: Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар

Тав. Хэрэгжүүлэх хугацаа

2022 оны 09-12 дугаар сар

Зургаа. Хүрэх үр дүн

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал, хуулийн төслийн саналыг Эрүүл мэндийн яаманд хүргүүлсэн байна.